



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2019 он 11 дугаар  
сарын 14-ны өдөр

Дугаар ХЭР  
3209

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Н.ОЮУНДАРЬ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улаанбаатар-Дарханы чиглэлийн авто замын ажлын явцын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: З. хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



0014723

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.ОЮУНДАРИАС МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

**Асуулга 1. Хүйтний улирал эхэлж, цас орж, халтиргаа гулгаа үүсэхээс өмнө замын ажлыг гэрээнд заасан хугацаанд дуусгаж, ашиглалтад оруулах боломжтой эсэх талаар:**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замд их засвар, шинэчлэлт хийхээр тусгагдсан.

Засгийн газраас тус чиглэлийн авто замын сүлжээний ач холбогдол, өсөн нэмэгдэж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн байдлыг харгалзан 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх шийдвэрийг 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 284 дүгээр тогтоолоор гаргасан ба авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх техникийн шийдлийг одоо байгаа 2 эгнээ бүхий замыг шинэчлэн сайжруулах замаар ашиглаж, нэмж 2 эгнээ авто замыг шинээр барихаар тодорхойлсон болно.

Тус бүтээн байгуулалтын ажлыг дараах байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

1. Азийн хөгжлийн банк /цаашид АХБ/-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд одоо байгаа 204.11 км бүхий 2 эгнээ авто замыг 4 эгнээ болгохтой уялдуулан өргөтгөн шинэчлэж, хүчитгэх ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба зам барилгын ажлыг 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхэлсэн.

2019 оны зам барилгын ажлын технологийн хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан өвлийн улиралд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор авто замын үндсэн трассын дагууд 11 дүгээр сарын 1-ний өдрөөс зорчих хөдөлгөөнийг нээгээд байна.

Зам барилгын ажлын гэрээг 2019 оны 6 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд байгуулсан ба гэрээнд авто замыг "Ажил эхлүүлсэн" өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд гүйцэтгэхээр заасан. Зөвлөхөөс "Ажил эхлүүлэх" мэдэгдлийг гүйцэтгэгч байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдөр өгсөн.

2. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр шинээр 202.42 км 2 эгнээ авто замыг барьж байгуулахаар төлөвлөсөн ба Зээлийн ерөнхий хэлэлцээрийг 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр байгуулж, Улсын Их Хурлаар 9 дүгээр сарын 12-ны өдөр соёрхон баталсан. Төслийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд зам барилгын ажлын гүйцэтгэгч, зөвлөхийг сонгон шалгаруулах ажлыг 2019 оны 6 дугаар сараас хэрэгжүүлж байна. Зам барилгын ажлыг 2020 оны зам барилгын улиралд эхлүүлэх юм.

**Асуулга 2. Зам барих ажил удааширч байгаагийн шалтгаан юу болох, ажил гүйцэтгэж байгаа компаниудын үйл ажиллагаанд тавьж байгаа хяналт хангалттай байгаа эсэх талаар:**

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдөр эхэлсэн. Зам барилгын ажлыг богино хугацаанд хэрэгжүүлэх хүрээнд 5 багц хэсгээр гүйцэтгэгчийг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу олон улсын тендерээр сонгон шалгаруулсан.

Иймд дотоодын худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийг мөрдөөгүй болно.

Авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын 65 хувийг 2019 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч нийт ажлын гүйцэтгэл одоогоор 31.7 хувьтай байгаа ба төлөвлөгөө 33.3 хувийн хоцрогдолтой хэрэгжиж байна.

Төлөвлөгөөний хоцрогдолд цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал нөлөөлсөн хэдий ч зарим зам барилгын ажлын гүйцэтгэгч байгууллагын ажлын удирдлага, зохион байгуулалт, менежментийн хангалтгүй байдал нөлөөлсөн. Тухайлбал, төслийн замын Багц 2 болон Багц 4 дүгээр хэсгийн зам барилгын ажлын хэрэгжилт удаашралтай 15.98 болон 15.1 хувийн хэрэгжилттэй байгаа ба тус ажлуудыг нэг компани гүйцэтгэж байгаа болно.

Ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн яам, Төсөл хэрэгжүүлэх нэгж, төслийн зөвлөх компаниас удаа дараа үүрэг, чиглэл, зөвлөмж өгч ажилласан боловч тодорхой ахиц гараагүй, ажлын явц удаашралтай байна.

Иймд яамны зүгээс гэрээнд заасны дагуу гүйцэтгэгч байгууллагатай хариуцлага тооцох, байгуулсан гэрээг цуцлах арга хэмжээ авахаар ажиллаж байгаа ба гэрээг цуцлах саналыг төслийн санхүүжүүлэгч байгууллага АХБ-нд холбогдох журмын дагуу 2 удаа албан ёсоор (2019.08.12 болон 2019.09.27-ны өдөр) тавьсан.

АХБ-аас тус хүсэлтэд одоог хүртэл хариу ирүүлээгүй байна. Мөн яамны удирдлагуудын түвшинд АХБ-ны суурин төлөөлөгчийн газартай хэд хэдэн уулзалт хийж төслийн хэрэгжилтийн явцын талаар болон дээрх гүйцэтгэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг цуцлах асуудлыг хэлэлцэж ярилцсан.

Албан бусаар АХБ-ны Зүүн Азийн газрын Тогтвортой дэд бүтцийн хэлтэс (*тус хэлтэс нь Монгол Улсад хэрэгжиж буй зам тээврийн салбарын төсөл, арга хэмжээг хариуцдаг*) нь дээрх зам барилгын ажлын гэрээг цуцлахтай холбогдох хүсэлтийг АХБ-ны Хуулийн хэлтэс болон бусад холбогдох газруудтайгаа зөвшилцэж байгаа талаарх мэдээллийг ирүүлээд байна.

АХБ-аас 2019 оны 11 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд төслийг хариуцсан мэргэжилтэн Монгол Улсад ирж ажиллах ба тус мэргэжилтэнтэй гэрээ цуцлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Зам барилгын ажилд АХБ-ны холбогдох журмын дагуу олон улсын ФИДИК (FIDIC - олон улсын инженерүүдийн нийгэмлэгээс гаргасан гэрээний загвар)-ын гэрээг мөрдлөг болгон хэрэгжүүлж байгаа ба тус гэрээ эрх зүйн хүрээнд зам барилгын ажилд өдөр тутмын техник, технологийн хяналт тавих зөвлөх баг гүйцэтгэж байна.

Зөвлөх багаар Энэтхэг Улсын "Intercontinental Consultants & Technocrats Pvt Ltd" компани болон Монгол Улсын "Ай Си Ти Сайн Консалтинг" ХХК-ийн түншлэл ажиллаж байгаа болно.

Ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хяналт тавих, хэрэгжилтийн явцад тулгамдаж буй асуудлыг цаг алдалгүй газар дээр нь шийдвэрлэх, холбогдох удирдлага зохион байгуулалт, зөвлөмж чиглэлээр хангах хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамны зүгээс ихээхэн анхаарч ажиллаа. Тухайлбал яамны удирдлага, холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд төслийн ажлын талбайд нийт 1,936 хүн/цаг ажилласан тооцоо судалгаа гарсан.

**Асуулга 3. Зам барих ажлын санхүүжилт хугацаандaa хийгдэж байгаа эсэх болон туслан гүйцэтгэгч Монгол аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх талаар:**

Зам барилгын ажил нь АХБ-ны МОН-3129 зээлийн хөрөнгөөс 100% санхүүжих ба ажлын санхүүжилт нь АХБ-ны холбогдох дүрэм, журам болон гэрээ эрх зүйн хүрээнд шийдвэрлэгддэг болно. Санхүүжилт тогтоосон хугацаанд хийгдэж байна.

Гүйцэтгэгч байгууллагаар БНХАУ-ын компаниуд ажиллаж байгаа ба тус компаниуд нь ажлаа эрчимжүүлэх хүрээнд Монгол компаниудтай туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулж ажилласан.

Гүйцэтгэгчийн болон туслан гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээнд захиалагчийн зүгээс хяналт тавьж, дотоодын компаниудын эрх ашгийг хамгаалах холбогдох зөвлөмж, чиглэлээр ханган ажиллаж байна. Багц 2 болон Багц 4 хэсгийн хувьд туслан гүйцэтгэгч компаниуд санхүүжилтээ авч чадахгүй байна гэсэн асуудал гарсан. Хоёр аж ахуйн нэгжийн хоорондын асуудалд Зам, тээврийн хөгжлийн яамнаас шууд оролцох боломжгүй байна.

**Асуулга 4. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замд гарах осол, зөрчлийг бууруулах талаар ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар:**

Төслийн зам барилгын ажлын хэрэгжилтийн явцад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хяналт тавих үүрэг бүхий тээврийн цагдаагийн гэрээт нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 38 гэрээт тээврийн цагдаа хөдөлгөөнт эргүүлээр ажиллаж, хяналт тавин илэрсэн зөрчлийг шийдвэрлэх арга хэмжээг авч байна.

Өвлийн улиралд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд дээр дурдсанчлан үндсэн авто замын трассаар 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хөдөлгөөн нээсэн. Хөдөлгөөн нээхтэй холбогдуулан Тээврийн цагдаагийн албатай хамтран авто зам дагууд ажиллаж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой зөвлөмж өгсөн. Үүний дагуу авто замын үзэгдэх орчинг сайжруулах, тэмдэг, тэмдэглэгээ суурилуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Түүнчлэн авто замаар зорчих зөвлөмж гарган хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон төлбөр хураах цэгүүдээр сурталчилж байна. Мөн Зам тээврийн хөгжлийн төвөөс авто замын дагууд хөдөлгөөнт эргүүл ажиллуулж эхлээд байна.

-----оОо-----